



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН РЕКТОРЫН ТУШААЛ

2026 оны 06 сарын 12 өдөр

Дугаар А/291

Улаанбаатар хот

“Сургалтын төвийн нийтлэг журам” батлах тухай

Дээд боловсролын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.2 дахь хэсэг, МУИС-ийн Дүрмийн 5.4.1, 5.4.8.5 дахь хэсэг, МУИС-ийн Хөдөлмөрийн дотоод журмын 6.5 дахь хэсэг, МУИС-ийн Ректорын 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн А/202 дугаар тушаал, МУИС-ийн судалгааны хүрээлэн, төвийн үйл ажиллагааны журам"-ын 2.2.4, 3.2.1 дэх хэсэг, МУИС-ийн Ректорын зөвлөлийн 2026 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. МУИС-ийн “Сургалтын төвийн нийтлэг журам”-ыг хавсралтаар баталж, 2026 оны 06 дугаар сарын 09-ний өдрөөс мөрдсүгэй.

2. МУИС-ийн Захирлын 2017 оны 06 дугаар сарын 23-ны өдөр батлагдсан “МУИС-ийн судалгааны хүрээлэн, төвийн үйл ажиллагааны журам”-ыг 2026 оны 06 дугаар сарын 09-ны өдрөөр хүчингүй болсонд тооцсугай.

3. Энэхүү журам батлагдсантай холбогдуулан бүрэлдэхүүн/ салбар, ахлах сургуулийн захирлуудад 30 хоногийн дотор Сургалтын төвийн эрхлэгч, ажилтны ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулан баталж, гэрээг байгуулах, шинэ журмын дагуу сонгон шалгаруулалтыг зохион байгуулсугай.


4. МУИС-ийн сургалтын чиг үүрэг бүхий төвийн үйл ажиллагааны дотоод журмыг МУИС-ийн сургалтын төвийн нийтлэг журамд нийцүүлэн боловсруулж, батлуулахыг төвийн эрхлэгч нарт үүрэг болгосугай.

5. МУИС-ийн сургалтын бус чиг үүрэг бүхий төв, захиргааны бүтцийн төв, судалгаа, эрдэм шинжилгээний төв, олон улсын хамтын ажиллагааны гэрээний дагуу байгуулагдсан төвүүд өөрийн үйл ажиллагааны журмыг шинэчлэн боловсруулж, батлуулахыг төвийн эрхлэгч нарт үүрэг болгосугай.

6. Сургалтын төвийн эрхлэгчийн албан тушаалын цалингийн сүлжээг шинэчлэн боловсруулж батлуулахыг Төлөвлөлт, хөрөнгө оруулалт эрхэлсэн проректор (Б. Даваасүрэн)-д үүрэг болгосугай.


7. Батлагдсан журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сургалт, оюутны хөгжил эрхэлсэн проректор (Д.Заяабаатар), бүрэлдэхүүн сургуулийн захирал (Б.Болд-эрдэнэ, Б.Амарсанаа, Н.Батнасан, Б.Ганбат, Ч.Сономдагва, С.Мөнхбат), салбар сургуулийн захирал (Ц.Пүрэвсүрэн, Д.Алтанхуяг, Б.Мядагмаа), ахлах сургуулийн захирал (П.Түвшинтөр, Ц.Пүрэвсүрэн, Н.Дэлгэрмаа, Ш.Мандах) нарт даалгасугай.

РЕКТОР  Б.ОЧИРХУЯГ



1426132205

Монгол Улсын Их Сургуулийн ректорын
2026 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн
4/29 дугаар/дүгээр тушаалын хавсралт



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН СУРГАЛТЫН ТӨВИЙН НИЙТЛЭГ ЖУРАМ

НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1 Монгол Улсын их сургуулийн (цаашид МУИС гэх) сургалтын төвийн бүтэц, удирдлага, түүний чиг үүрэг, үйл ажиллагааны үнэлгээ, санхүүжилт болон татан буулгахтай холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2 Төвийн үйл ажиллагаанд Дээд боловсролын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, МУИС-ийн дүрэм, Хөдөлмөрийн дотоод журам, Албан хэрэг хөтлөлтийн журам, Сургалтын үйл ажиллагааны журам болон холбогдох хууль тогтоомжийг мөрдөнө.

1.3 Төвийн үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална.

- 1.3.1 Хууль дээдлэх;
- 1.3.2 Үйл ажиллагааны орлогоосоо санхүүжих;
- 1.3.3 Санхүүгийн тогтвортой байдлыг хангасан байх;
- 1.3.4 Сургалтын агуулга, арга зүй, үнэлгээ нь суралцахуйн үр дүнд суурилсан байх;
- 1.3.5 Ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;
- 1.3.6 Ил тод, хариуцлагатай байх;
- 1.3.7 Сургалтын үйл ажиллагаанд оюутны сайн дурын оролцоог хангах;
- 1.3.8 Ёс зүйг чанд мөрдөх;
- 1.3.9 Үйлчлүүлэгчийн итгэмжилсэн нууцыг чандлан хадгалах.

ХОЁР. Үйлчлэх хүрээ

2.1 МУИС-ийн сургалтын төвийн нийтлэг журам нь сургалт, дадлага, үнэлгээ, зөвлөх үйлчилгээ, шалгалтыг эрхлэн явуулах зорилго бүхий, бүрэлдэхүүн/салбар, ахлах сургуулийн захирлын шууд удирдлагад хамаарах нэгжийн үйл ажиллагаанд үйлчилнэ.

2.2 МУИС-ийн сургалтын төвийн нийтлэг журамд нийцүүлэн сургалтын төв нь өөрийн үйл ажиллагааны журмыг тусгасан дотоод журамтай байна.

2.3 Энэхүү журам нь сургалтын бус чиг үүрэг бүхий төв, захиргааны бүтцийн төв, судалгаа, эрдэм шинжилгээний төв, олон улсын хамтын ажиллагааны гэрээний дагуу байгуулагдсан төвийн үйл ажиллагаанд үйлчлэхгүй.

2.4 МУИС-ийн сургалтын бус чиг үүрэг бүхий төв, захиргааны бүтцийн төв, судалгаа, эрдэм шинжилгээний төв нь өөрийн үйл ажиллагааг зохицуулсан

журамтай байна. Олон улсын хамтын ажиллагааны гэрээний дагуу байгуулагдсан төв нь тус гэрээнд нийцүүлэн үйл ажиллагааны журмыг тусгасан дотоод журамтай байна.

ГУРАВ. Бүтэц, удирдлага

3.1 Төв нь сургалт, дадлага, үнэлгээ, зөвлөх үйлчилгээ, шалгалт зэрэг үйл ажиллагааны чиглэлээр тогтвортой үйл ажиллагаа явуулах нөхцөлийг хангасан бүтэцтэй байна.

3.2 Төв нь албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэг, үйл ажиллагааг илэрхийлсэн бэлгэдэл, логотой байна.

3.3 Бүрэлдэхүүн/салбар, ахлах сургуулийн нэгж нь сургалтын төв байгуулах саналаа Сургалт эрхэлсэн проректорт танилцуулж, зөвшөөрлийг үндэслэн Ректоратын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ.

3.4 Төв байгуулах саналд дараах асуудлыг тусгасан байна:

- 3.4.1. Төв байгуулах үндэслэл, шаардлага;
- 3.4.2. Үйл ажиллагааны төлөвлөгөө;
- 3.4.3. Санхүүгийн тогтвортой байдлын үнэлгээ;

3.5 МУИС-ийн Ректорын тушаалаар сургалтын төвийг байгуулж, орон тоог батална.

3.6 Төвийн эрхлэгчийг 3 жилийн хугацаатай ректор томилно. Үр дүнгийн гэрээний гүйцэтгэлийг үндэслэн төвийн эрхлэгчийг дахин нэг удаа 3 жилийн хугацаатай үргэлжлүүлэн ажиллуулж болно.

3.7 Төвийн эрхлэгч нь МУИС-ийн үндсэн орон тоон дээр ажилладаг, тухайн сургалтын үйл ажиллагаа хэрэгжүүлэх чиглэлээр мэргэшсэн, их сургууль, эрдэм шинжилгээний байгууллагад 6-аас доошгүй жил ажилласан, магистр болон түүнээс дээш зэрэгтэй байна.

3.8 Төвийн эрхлэгч нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

- 3.8.1. Төвийг төлөөлж, өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;
- 3.8.2. Төвийн санхүүгийн гүйлгээг зориулалтын дагуу гүйцэтгэж, санхүүгийн тайланг хугацаанд нь гаргах;
- 3.8.3. Төвийн багш, ажилтны ажил үүргийн гүйцэтгэлд жил бүр үнэлгээ хийж, дүгнэлтийг шууд удирдлагад танилцуулах;
- 3.8.4. Төвийн албан бичиг, хурлын тэмдэглэлийг хянаж, архивд хүлээлгэн өгөх;
- 3.8.5. Төвийн сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах үүднээс сургалтын хуваарь, анги танхим, техник тоног төхөөрөмжийн хангамж, хэвийн ажиллагаанд хяналт тавьж ажиллах;
- 3.8.6. Төвийн сургалтын төлөвлөгөөг хичээлийн жил эхлэхээс өмнө боловсруулж, шууд удирдлагаар батлуулж мөрдөх;
- 3.8.7. Төвийн ажилтан бүрийн ажлын байрны тодорхойлолтыг боловсруулж, шууд удирдлагаар батлуулах;

3.8.8. Төвд ажиллах багш, ажилтныг тогтоосон шаардлага, журмын дагуу сонгон шалгаруулж, саналаа шууд удирдлагад танилцуулж томилуулах;

3.9 Төвийн эрхлэгч нь үндсэн орон тоогоор эсхүл МУИС-ийн үндсэн орон тооны ажилтан хавсран гүйцэтгэж болно.

3.10 Төвийн эрхлэгч нь үндсэн орон тоонд ажиллах тохиолдолд МУИС-д мөрдөж буй цалингийн сүлжээгээр цалинг тогтооно. Хэрэв хавсран гүйцэтгэх тохиолдолд тухайн хавсран гүйцэтгэж буй албан тушаалын үндсэн цалингийн 40 хувьтай тэнцэх хэмжээний нэмэгдэл хөлс олгоно.

3.11 Төвийн ажилтан нь үндсэн орон тоонд ажиллах тохиолдолд МУИС-д мөрдөж буй цалингийн сүлжээгээр цалинг тогтооно. Төвийн ажилтан орон тооны бусаар ажиллах тохиолдолд МУИС-д мөрдөж буй цалингийн сүлжээний шатлалд дүйцүүлэн хөлс олгоно.

ДӨРӨВ. Үйл ажиллагааны үнэлгээ

4.1 “Төвийн сургалтын үйл ажиллагааны төлөвлөгөө”-г хичээлийн жилийн эхэнд боловсруулж, шууд удирдлагад танилцуулж батлуулна.

4.2 Бүрэлдэхүүн/салбар, ахлах сургуулийн захирал нь тухайн төвийн үндсэн чиг үүргийн хүрээнд үйл ажиллагааны үнэлгээний шалгуур үзүүлэлтийг боловсруулж батална.

4.3 Төвийн сургалтын үйл ажиллагааны тайланг хичээлийн жилийн төгсгөлд шууд удирдлагад танилцуулж хэлэлцүүлнэ.

4.4 Сургалтын төвийн үнэлгээ нь тухайн төвийн эрхлэгч, багш, ажилтны үр дүнгийн гэрээг сунгах, цуцлах үндэслэл болно.

4.5 Сургалтын төвийг дараах үндэслэлээр татан буулгана.

4.5.1 Төлөвлөгөөт үйл ажиллагаагаа хэрэгжүүлж дууссан;

4.5.2 Гүйцэтгэлийн тайланг ирүүлээгүй;

4.5.3 Гүйцэтгэлийн үнэлгээ нь 2 жил дараалан “хангалтгүй” үнэлэгдсэн;

4.5.4 Санхүүжилтийн эх үүсвэргүй.

4.6 Төвийн эд хөрөнгө, татан буугдахтай холбогдох эд хөрөнгийн харилцааг “МУИС-ийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-аар зохицуулна.

ТАВ. Санхүүжилт

5.1 Төвийн өмч хөрөнгө нь МУИС-ийн өмчлөлд байна.

5.2 Сургалтын төвийн санхүүгийн гүйлгээг МУИС-ийн бүрэлдэхүүн/салбар, ахлах сургуулийн дансаар хийнэ.

5.3 Төвийн төсөв дараах эх үүсвэрээс бүрдэнэ.

5.3.1 Төвийн үйл ажиллагааны орлого;

5.3.2 Хандив, тусламж;

5.3.3 Хуульд нийцсэн бусад эх үүсвэр.


5.4 Төвийн санхүүгийн тайланг МУИС-ийн санхүүгийн нэгж хянана.

5.5 Төвийн эрхлэгч санхүүгийн гүйлгээг зориулалтын дагуу гүйцэтгэж, санхүүгийн тайланг хугацаанд нь МУИС-ийн санхүүгийн нэгжид хүргүүлнэ.

ЗУРГАА. Бусад

6.1. Энэхүү журам батлагдсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилнэ.

6.2. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.



xxx